



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ

2017 оны 11 сарын 29 өдөр

Дугаар 142

Номгон

“Ахмадаа ачилъя” аймгийн дэд
хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1-ийн “ж”, 20 дугаар зүйлийн 20.1.7, Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2016 оны 2/3 дугаар тогтоолоор баталсан “Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 57 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Аймгийн хэмжээнд ахмад настны эрхийг хангах, амьжиргаа, хөгжил, оролцоог дэмжих, эрүүл насжих, гэр бүл, хамт олны нийгэмд эрх тэгш, сэтгэл хангалуун өөдрөг амьдрах ээлтэй орчныг бүрдүүлэх зорилгоор “Ахмадаа ачилъя” аймгийн дэд хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2. Хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөөг гарган аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусгаж, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төсөвт тусган батлуулж, хэрэгжилтийг бүтэн жилээр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдэд танилцуулахыг аймгийн Засаг дарга /Г.Батжаргал/-д даалгасугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.ОТГОНБАЯР

0117125

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 11 дүгээр сарын
29-ний өдрийн 142 дугаар тогтоолын хавсралт



**“АХМАДАА АЧИЛЪЯ” АЙМГИЙН
ДЭД ХӨТӨЛБӨР**

Нэг. Нийтлэг үндэслэл

Өнөө үед дэлхий нийтийн өмнө тулгарч байгаа нэг онцлог асуудал бол хүн амын насжилт юм. ДЭМБ-аас "Идэвхтэй урт наслалт"-ыг хүний амьдралын нэгэн үнэт баялаг гэж үзэж амьдралын чанарыг сайжруулах нь настай хүмүүсийн аюулгүй байдал, нийгмийн оролцоо, эрүүл мэндийн боломжийг нэмэгдүүлэх үйл явц мөн хэмээн тодорхойлсон байна.

Олон улсын хэмжээнд 1982 оны Венийн Насжилтын асуудлаарх Олон Улсын үйл ажиллагааны төлөвлөгөө, 1991 оны НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 46/91 дугаар тогтоолоор баталсан “Ахмад настай хүмүүсийн талаарх зарчмууд”, 1992 онд НҮБ-ын Ерөнхий Ассамблейн 47/5 дугаар тогтоолоор баталсан “Насжилтын талаарх тунхаглал” зэрэг батлан гаргасан баримт бичгүүдэд өндөр настнуудын эрхийг хамгаалахад оролцогч улс бүрийн хийх ёстой арга хэмжээг нарийвчлан заасан байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн арван зургадугаар зүйлийн 16.5 дахь хэсэгт Монгол Улсын иргэн “Өндөр наслах, хөдөлмөрийн чадвар алдах, хүүхэд төрүүлэх, асрах болон хуульд заасан бусад тохиолдолд эд, мөнгөний тусламж авах эрхтэй” болох, Ахмад настны тухай хууль, “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр, Нийгмийн даатгалын багц хуулиуд, Засгийн газрын 2016 оны 261 дүгээр тогтоолоор баталсан “Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлого”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.15, 4.4.9, 4.5.1, 4.6-д ахмад настны эрх, хамгааллыг баталгаажуулсан байна.

Баянхонгор аймгийн нийт хүн ам 2016 оны жилийн эцсийн байдлаар 85331 болж, үүнээс 50.6 хувь /43215/ эмэгтэйчүүд, нийт хүн амын 30621 буюу 35.9 хувь 0-17 хүртэл насны хүүхэд, 48077 буюу 56.3 хувь хөдөлмөрийн насны иргэд, 6633 буюу 7.8 хувь өндөр настан эзэлж байна. Ахмад настай хүмүүсийг насны бүтцээр нь авч үзвэл 55-60 насны 30.9 хувь, 60-64 насны 24.7 хувь, 65-69 насны 15.7 хувь, 70-аас дээш насны 28.7 хувь, 71.1 хувь буюу 4719 ахмад эмэгтэйчүүд байна.

Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийн байдлыг авч үзвэл хувиараа хөдөлмөр эрхэлдэг 5.3 хувь, төрийн байгууллагад ажилладаг 1.7 хувь, ажил хийх боломжтой 25.3 хувь, гэртээ 46.3 хувь, малчин 21.4 хувийг тус тус эзэлж байна.

Ахмадын дотор амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой 906 /13.6%/, харж хандах хүнгүй ганц бие 954 /14.4%/, байнгын асаргаанд 1270 /19.1%/, хөгжлийн бэрхшээлтэй 538 /8.1%/, ахмад байна.

Рашаан сувилал, амралтад 2016 оны байдлаар 904, ядуурал бууруулах төсөлд 43 ахмад хамрагдсан, асрамжийн үйлчилгээнд 9 ахмад хамрагдаж байна.

Байгууллагад харъяалагддаг 1168 ахмад /17.6%/, харъяалалгүй 5465 /82.4%/, ахмад настан байна. Ахмад настны эрх ашгийг хамгаалж аймаг, сумын ахмадын хороо, Баянхонгор сумын 9 багт ахмадын зөвлөл, ахмадын ажил мэргэжлийн 8 холбоо ажиллаж байна. Аймгийн төвд Ахмадын ордон, сумдад ахмадын танхимтай, ахмадын асрамжийн 1 төвтэй, Нэгдсэн эмнэлэгт ахмадын настны нэг эмч, ахмадын настны бодлого хариуцсан 22 мэргэжилтэн ажиллаж байна.

Монгол улсын Нийгмийн халамжийн хуулийн хүрээнд 2015 онд ахмад настан 54 хүнд 74.8 сая төгрөгийн тэтгэвэр, тэжээн тэтгэх үр хүүхэд, төрөл садангийн хүнгүй ганц бие ахмад настан иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа 4 хүнд 3.1 сая төгрөгний асаргааны тэтгэмж, Ахмад настны нийгмийн хамгааллын тухай хуулийн холбогдох заалтаар ахмад настны нийгмийн хамгааллын тусламж, хөнгөлөлтөд 7476 ахмад настан хамрагдаж, 564.2 сая төгрөгийг зарцуулсан байна.

Монгол Улсын “Эрүүл насжилт, настны эрүүл мэнд” үндэсний хөтөлбөр, Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Төрөөс ахмадын талаар баримтлах бодлого” гаргаж, “Ач санах” хуулийг батлуулж, азай буурлууддаа “Насны хишиг” тэтгэвэр олгох эрх зүйн орчинг бүрдүүлнэ”, “Тэтгэвэр, тэтгэмж, цалинг үе шаттай нэмэгдүүлнэ”, “Тэтгэврийн зээлийн хүүг бууруулах бодлого баримтална”, “Ахмадын зөвлөх үйлчилгээг бий болгож, хүүхэд, залууст ажлын дадлага, туршлага, мэргэжлийн ур чадварыг нь өвлүүлэх ажлыг зохион байгуулна”, “Ахмад настны асаргаа үйлчилгээ, сэргээн засах болон сувилахуйн үйлчилгээг өргөжүүлж, хувийн хэвшлийн асрамжийн газар байгуулахыг дэмжинэ”, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрт “Ахмад өндөр настнуудаа халамжлах, сэтгэл хангалуун өөдрөг байлгах зорилго бүхий “Ахмадаа ачилъя” хөтөлбөр хэрэгжүүлнэ”, “Ахмадын асрамжийн төв”-ийн барилгад засвар тохижилт хийж, ая тухтай орчинг бүрдүүлэхийн зэрэгцээ ахмадад үйлчлэх зориулалттай “Ахмадын амралт сувиллын газар байгуулах асуудлыг бодлогоор дэмжинэ” зэрэг зорилт нь хөтөлбөр боловсруулах үндэслэл болсон.

Хоёр. Хөтөлбөр боловсруулах хэрэгцээ шаардлага

Ахмад настангуудын бодит орлого болох тэтгэвэр нь амьжиргааныхаа хэрэгцээг хангаж чадахгүй байх, тэтгэвэрээ урт хугацаагаар зээлсэн, үр хүүхдүүд нь амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, эдийн засгийн идэвх доогуур байгаа нь тэдний амьжиргаанд сөргөөр нөлөөлж ялангуяа эрүүл мэнд доройтох, ядууралд өртөх нь өндөр байна.

Ахмад настангуудын орон байрны ая тухтай байдал нь алдагдсан, тэжээллэг, чанарлаг хоол хүнсний хэрэглээ нь хязгаарлагдмал, эрүүл мэндийн үйлчилгээнд тогтмол хамрагддаггүй эсхүл удаан хугацаагаар эмчилгээ хийлгэж байгаа, бусдын асаргаанд байдаг, эдгэшгүй өвчин, ганцаардлаас үүдэлтэй сэтгэл гутралд орсон, ахмад настны өвчлөл, нас баралтын түвшин бусад насны бүлгүүдтэй харьцуулахад өндөр байна.

Ахмад настны орлогыг нэмэгдүүлэх, ахмад настны хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, хуримтлуулсан мэдлэг, дадлага туршлагаа баяжуулж, залуу үедээ өвлүүлэн үлдээх, өөрөө хөгжих боломж олгох, ахмад настны эрүүл мэндийн болон асран сувилах үйлчилгээг өргөжүүлж, эрүүл насжихад нь дэмжлэг үзүүлэх, ахмад настны хамгааллын үйлчилгээг сайжруулах, нийгмийн идэвхтэй гишүүн байж, хүсэл сонирхлынхоо дагуу ая тухтай амьдрах орчинг бүрдүүлэх, амьдралын чанарыг дээшлүүлэх шаардлагатай байна.

Хүн амын насны бүлэг ахих тутам өндөр насны бэлэвсэн эмэгтэйчүүд эрэгтэйчүүдээс олон, өндөр настан тэргүүнтэй өрх цөөрч хүү, охинындоо амьдардаг өндөр настны эзлэх хувь нэмэгдэж байна. Энэ нь ахмадуудын оршин сууж байгаа орон нутгийн төр, захиргааны байгууллагаас тэдний нийгмийн асуудалд илүү анхаарах шаардлагатайг харуулж байна.

Гурав. Хөтөлбөрийн зорилго, баримтлах зарчим

3.1 Хөтөлбөрийн зорилго: Ахмад настангууд баялаг бүтээгч нийгмийн идэвхтэй гишүүн байж, эрүүл насжиж, гэр бүл, хамт олон, нийгэмд эрх тэгш, сэтгэл хангалуун өөдрөг амьдрах ээлтэй орчинг бүрдүүлэх

3.2. Баримтлах зарчим: Хөтөлбөрийг дор дурдсан үндсэн зарчим дээр тулгуурлан хэрэгжүүлнэ.

3.2.1. Бие даан амьдрах эрх: Зохистой хоол хүнс, орон байр, хувцасаар хангагдах

3.2.2. Нийгмийн амьдралд бүрэн дүүрэн оролцох эрх: Хөдөлмөрлөх, сурч боловсрох боломжтой байх, өөрт хамааралтай асуудлаар төрийн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцох, өөрсдийн мэдлэг, туршлагаа бусадтай хуваалцах, эвлэлдэн нэгдэх, ганцаардахгүй байх

3.2.3. Нийгмийн халамж, хамгаалалд хамрагдах эрх: Гэр бүл, үр хүүхдээрээ халамжлуулах, эрүүл мэндийн үйлчилгээ хүртэх, тэтгэвэр авах, нийгмийн халамжийн бусад үйлчилгээнд хамрагдах

3.2.4. Алдагдсан боломж, чадвараа нөхөн сэргээх эрх

3.2.5. Нэр төр, эрхэм зэргээ хүндэтгүүлэх эрх: Хүндлүүлэх, аюулгүй амьдрах, мөлжлөг, сэтгэл санааны дарамтаас ангид байх, ялгаварлан гадуурхагдахгүй байх

Дөрөв. Хөтөлбөрийн зорилт, үр дүн, үйл ажиллагаа

Зорилт 1. Ахмад настны хөдөлмөрийн чадамжид тохирсон ажлын байрыг бий болгохыг урамшуулах, хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх

Үр дүн 1. Ахмадуудын настангуудын ажил хийх боломжийг нэмэгдүүлж, ажил хийх боломжтой, гэртээ байгаа 71.6 хувийг хөтөлбөр хэрэгжих хугацаанд 5-10 хувиар бууруулсан байна.

Нэгдүгээр зорилтын хүрээнд хийгдэх үйл ажиллагаа

1.1. Ахмад настныг ажилд зуучлах, нөхөрлөл, хоршооны хэлбэрээр хөдөлмөр эрхлэхийг дэмжих, бизнес инкубацийн үйлчилгээ үзүүлэх, жижиг зээл олгох, хөдөлмөр эрхлэлтийн сургалтад хамруулах

1.2. Ахмад настан нь залуу үед амьдрах ухаан, аж ахуй эрхлэх болон бусад чиглэлээр танхимын, зайны, шавь сургалт явуулахыг дэмжиж ажиллах

1.3. Төрийн байгууллагууд зөвлөх мэргэжилтнээр ажиллах мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ахмад настны бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлж, тэднийг төрийн бодлого, хууль тогтоомж боловсруулах, бүтээн байгуулалтын төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэхэд зөвлөгөө өгөх ажилд оролцуулах арга хэмжээ авах

1.4. Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвартай ахмад настны бүртгэл, мэдээллийн санг бүрдүүлж, тэднийг мэргэжлийн чиглэлээр нь сургагч багшаар бэлтгэх, зөвлөх үйлчилгээнд зуучлах ажлыг зохион байгуулах

1.5. Ахмад настны хөдөлмөрийн чадамжид тохирсон ажлын байрыг бий болгон ажиллуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэнийг урамшуулах журам боловсруулан хэрэгжүүлэх

1.6. Ахмад настны санаачилгаар үүсгэн байгуулагдсан бөгөөд нийт ажиллагсадын 50-аас доошгүй хувийг нь ахмад настан эзэлдэг аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөл, хоршоонд аймаг, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр хөрөнгө, зээл олгохыг дэмжих

1.7. Аж ахуйн нэгж, байгууллага нь мэргэжлийн ур чадвар, дадлага туршлагатай ахмад настныг үргэлжлүүлэн ажиллуулахыг дэмжих

1.8. Ахмад малчид залуу малчдыг бэлтгэн чадваржуулах, өөрийн туршлагаа өвлүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх чиглэлээр “Малчдын халаа” арга хэмжээг хэрэгжүүлэх

1.9. Ахмадуудад орлогоо нэмэгдүүлэх, хөгжих шинэ шинэ боломжуудыг бий болгох, ахмад настанд тохирсон жижиг дунд үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж авах, байрны түрээс олгох санхүүгийн дэмжлэг үзүүлэх

1.10 Ахмад настангуудыг зохион байгуулалттай хөдөлмөр эрхлэхэд дэмжлэг үзүүлэх /аймаг, байгаль орчноо цэвэр байлгах, аргал түүх гэх мэт/

Зорилт 2. Хүн амыг эрүүл насжихад бэлтгэж, ахмад настны эрэлт хэрэгцээнд нийцсэн нийгмийн суурь үйлчилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг тэгш, хүртээмжтэй, чанартай үзүүлж, нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, хөгжих нөхцөлийг бүрдүүлэх

Үр дүн 2. Ахмад настны нас баралтын түвшин буурч, тэдний оролцсон арга хэмжээ жил бүр нэмэгдэж, хамрагдалт 20-30% өссөн байна.

Хоёрдугаар зорилтын хүрээнд хийгдэх үйл ажиллагаа

2.1 Ахмад настанд эрэлт хэрэгцээг судлан төрөл бүрийн зөвлөгөөг өгөх үйлчилгээ үзүүлэх

2.2. Баянхонгор суманд ахмад настныг хооллох, эрүүл мэндийн дасгал хөдөлгөөн хийлгэх, эрүүлжүүлэх, хөгжүүлэх орчин бүхий өдрийн сувиллыг ажиллуулах

2.3. Ахмад настанд туслах хүсэл, сонирхолтой сайн дурын байгууллага, ажилтны үйл ажиллагаа, санал санаачлагыг дэмжих

2.4. Хүнд өвчтэй, байнгын асаргаа сувилгаа шаардлагатай ахмад настныг өдрийн эмчилгээ, сувилахуйн болон сэргээн засахын тусламж, үйлчилгээнд хамруулах, шаардлагатай тохиолдолд гэрээр тусламж, үйлчилгээ үзүүлэх

2.5. Бие даан амьдрах чадваргүй ахмад настныг аймгийн төвийн ахмад настны асрамжийн үйлчилгээнд хамруулах

2.6. Өрхийн амьжиргааны түвшиний судалгаагаар доогуур түвшинд байгаа ахмад настанд хүнсний бүтээгдэхүүн авах эрхийн бичиг олгох

2.7. Гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн ахмад настанг холбогдох хуульд заасны дагуу хүчирхийллээс хамгаалах, нэг цэгийн үйлчилгээнд хамруулах

2.8. Сум, багийн Нийгмийн түншлэлийн баг дэмжлэг, туслалцаа шаардлагатай ахмад настны нөхцөл байдлыг судлан тогтоож, хэрэгцээт дэмжлэг, туслалцаа, үйлчилгээг тодорхойлж, үйл ажиллагааны төлөвлөгөө гарган нийгмийн суурь үйлчилгээ, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх

2.9. Ахмад настангуудыг эрүүл мэндийн үзлэгт жилд 1удаа хамруулан, судалгаа мэдээллийн сан бүрдүүлэн, эмчлэн эдгэрүүлэх, эмчилгээ, сувилгаа зайлшгүй шаардлагатай ахмадуудыг жилд нэг удаа хөнгөлөлттэй үнээр амралт, сувиллын газарт амруулах

2.10. Ахмад настанд олгох нийтийн тээврийн хэрэгслийн төлбөрийг төсвөөс санхүүжүүлэх

2.11. Сум, өрхийн эрүүл мэндийн төв ахмад настанд зориулж насжилтаас үүдэлтэй өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө, сургалтыг улиралд нэгээс доошгүй удаа зохион байгуулах

2.12. Сум, өрхийн эрүүл мэндийн төв хэвтрийн болон архаг өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй ахмад настныг байнгын хяналтад авч, асран сувилах тусламж үзүүлэх явуулын үйлчилгээг ахмад эмч, сувилагч, тусгайлан бэлтгэсэн сайн дурын ажилтныг оролцуулан хэрэгжүүлэх

2.13. Өндөр насны тэтгэвэр тогтоолгох хугацаа дөхсөн болон өндөр насны тэтгэвэр тогтоолгож байгаа ахмад настныг нийгэм, эдийн засаг, сэтгэл зүйн хувьд бэлтгэх ажлыг хэрэгжүүлэх

2.14. Нутгийн захиргааны байгууллага ахмад настанд биеийн тамир, спорт, соёл, урлагийн барилга, байгууламж, талбайг үнэ төлбөргүй ашиглуулах, ахмад настны дунд биеийн тамир, спорт, урлаг, соёлын арга хэмжээг зохион байгуулах, ахмадын баг, хамтлаг, клубыг үйл ажиллагаа явуулах байраар үнэ төлбөргүй хангах

2.15. Сумын Засаг даргын Тамгын газар сумын Ахмадын хороог ажиллах байр, үйл ажиллагаагаа явуулах нөхцөлөөр хангаж, санхүүгийн болон бусад дэмжлэг үзүүлэх

2.16. Ахмад настанг орон нутгийн байгалийн үзэсгэлэнт газар, сум хийдээр хамт олноор аялах, эрүүл агаарт явах боломжийг бүрдүүлэх, дэмжлэг үзүүлэх

2.17. Ахмад настны хийсэн зүйл болон тэдэнд зориулсан сүү цагаан идээ, хүнсний “Ахмадаа ачилъя” дэлгүүрийг аймгийн төвд ажиллуулах

2.18. Ахмад настанд гэрийн үйлчилгээ үзүүлсэн сайн дурынханыг урамшуулах журам боловсруулан хэрэгжүүлэх

Зорилт 3. Ахмад настны талаар ойлголт хандлагыг төлөвшүүлж, гэр бүл, хамт олон, нийгэмд эрх тэгш, сэтгэл хангалуун амьдрах ээлтэй орчинг бүрдүүлэх

Үр дүн 3. Ахмад хүний үнэ цэнэ, үнэлэмж дээшилж, тэднээс суралцах орчин бүрдэж, өөрийгөө хөгжүүлэх, чадваржуулах хүсэл сонирхолтой, нийгмийн үйл хэрэгт оролцсон ахмадуудтай тоо нэмэгдсэн байна.

Гуравдугаар зорилтын хүрээнд хийгдэх үйл ажиллагаа

3.1. Ахмад настнуудыг ажиллаж байсан байгууллагатайгаа байнгын холбоотой байлгах, ажил амьдралын асуудлаа харилцан ойлголцож, хүндлэгдэж байх нөхцлийг бүрдүүлэх

3.2. Гэр бүл, хамт олон, хүүхэд, залуучуудад ахмадаа дээдлэх, ахмадаа хүндлэх хүндлэлийг төлөвшүүлэх гурван үеийн чуулган, зөвлөгөөн, гэр бүлийн баяр, ургийн баяр, насны ой, хөдөлмөрийн алдар тэмдэглэхийг идэвхжүүлэх

3.3. Ахмад настнууд өөр хоорондоо бүлэг холбоо, клуб байгуулах замаар “Нэг ахмад-Нэг ахмаддаа урам хайрлая” уриан дор бие биедээ туслах сайн дурын хүмүүнлэгийн ажлыг өргөжүүлэх

3.4. Ахмадын зөвлөх үйлчилгээний төрлийг нэмэгдүүлж, хүүхэд, залуучууд, ажилтан, албан хаагч, залуу малчдад зөвлөгөө өгөх, шавь сургалт, дагалдан сургах ажлыг гэрээгээр, түр хугацаагаар хийлгэх

3.5. Ахмадууд мэдлэг, туршлагаа залуустайгаа хуваалцах, тэдэнд өвлүүлэх “Хүн ахтай дээл захтай” төсөлт арга хэмжээ зохион байгуулах

3.6. Орон нутгийн телевизид “Ахмадын сургаал алт” нэвтрүүлгийн цагтай болж, ахмадуудыг нэвтрүүлэгт оролцуулж, ажил амьдралын туршлагыг түгээх

3.7. Орон нутагт амьдарч байгаа алдар цолтон, ахмад дайчин, урлаг спортын гавьяатнуудтай хүүхэд залуучууд, иргэдийн нөхөрсөг уулзалт ярилцлага зэрэг олон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулж, хөдөлмөрийн үр шимийг мэдрүүлэх нөлөөллийн ажлыг өргөжүүлэх

3.8. Ахмадуудын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэхэд чиглэсэн сонин, сэтгүүлээр үйлчлэх, дуулж, бүжиглэх, спорт тоглоом тоглох, хийн болон бясалгал дасгал хийх, эрүүл мэндийн асаргаа сувилгаа авах, сэтгэл зүйн зөвлөгөө авах, алжаал тайлах орчин нөхцөлийг бүрдүүлэх

3.9. Ахмад настан үл хөдлөх хөрөнгө эзэмших, ашиглах, захиран зарцуулах, гэр бүлийн гишүүнээс туслалцаа дэмжлэг авахад туслах

3.10. Ахмад настангууд очер дугааргүй үйлчилгээг авах орчинг бүрдүүлэх

3.11. Бүх байгууллага “Ахмадын сан”-тай болох, харьяалалгүй ахмадуудыг албан байгууллагын харьяалалтай болгох ажлыг хэрэгжүүлэх

3.12. Ахмадууд настны нийгмийн амьдралд оролцох оролцоог дээшлүүлэх

Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга замууд

5.1. Хөтөлбөр боловсруулсан ажлын хэсэг хөтөлбөрийн хэрэгжилтийг хариуцан орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхэд удирдлага, арга зүйгээр хангаж ажиллана.

5.2. Хөтөлбөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөг аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлэн баталгаажуулж бүх сумдад хүргүүлнэ.

5.3. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөнд хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа бүрийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт бүрийг төлөвлөн эзэнжүүлж, хэрэгжилтийг зохион байгуулах чиглэлээр аймгийн Засаг даргын захирамжаар үүрэгжүүлж, хяналт тавих ажлыг Нийгмийн бодлогын хэлтсийн даргад үүрэг болгоно.

5.4. Хөтөлбөрийн төсөл арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх төсөл сонгон шалгаруулах замаар хэрэгжүүлнэ. Төсөл арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн тайланг жил бүр аймгийн Засаг даргын зөвлөлөөр хэлэлцүүлсний дараа аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралдаанд оруулж, үнэлүүлнэ.

Зургаа. Хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт

6.1. Ахмад настны талаар гарсан шийдвэр, эрх зүйн актын тоо

6.2. Ахмадуудад ээлтэй орчин, дэд бүтэц бий болгосон байгууллагын тоо, түүнд зарцуулсан хөрөнгийн хэмжээ

6.3. Ахмадуудад чиглэсэн ажлын салбар дундын үйл ажиллагаа, түүний тоо, үр дүн

6.4. Нийгмийн цогц суурь үйлчилгээнд хамрагдсан ахмадын тоо

6.5. Ахмадын хөгжүүлэх чиглэлээр зохион байгуулсан арга хэмжээнд оролцсон ахмадын тоо

6.6 Нийт өвчлөлд ахмад настны өвчлөлийн эзлэх хувь, нас баралтын түвшин

6.7. Ахмад настны хөдөлмөр эрхлэлтийн түвшин

6.8. Ахмад настны амьжиргааны түвшин

Долоо. Хэрэгжилтийн үнэлгээний арга хэлбэр, үе шат

7.1. “Ахмадаа ачилъя” хөтөлбөрт тусгагдсан зорилтын хүрээнд жил бүр үйл ажиллагааны төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.

7.1.1. 1-р үе шат буюу 2017-2019 он /2019 оны 09 дүгээр сард үнэлгээ хийх/

7.1.2. 2-р үе шат буюу 2019-2021 он /2021 оны 09 дүгээр сард үнэлгээ хийх/

7.2. Явцын үнэлгээ буюу мониторинг 2 жил тутамд зохион байгуулж, эцсийн үнэлгээг 2021 онд зохион байгуулж, үр дүнг тооцно.

7.3. Төлөвлөгөөний хэрэгжилтийн явцыг аймгийн ажлын хэсэг аймгийн Засаг дарга, аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргад танилцуулж, тайлагнах ба Нийгмийн бодлогын хэлтсийн тухайн асуудал хариуцсан мэргэжилтэн, аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, аймгийн Ахмадын хороо иргэдэд мэдээлэх ажлыг хариуцан зохион байгуулна. Бүх сумын Ахмадын хороо хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд санаачилгатай ажиллана.

7.4. Биелэлтийн явц, үр дүн, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг Нийгмийн бодлогын хэлтсийн дарга холбогдох байгууллагад уламжилж шийдвэрлүүлж ажиллана.

Найм. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын удирдлага, зохион байгуулалт

8.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд хөрөнгө оруулалт, аймаг, сумын нийгэм эдийн засаг, бусад төсөл хөтөлбөр, төсвийн санхүүжилттэй нягт уялдуулан зохицуулах, хэрэгжүүлэх ажлыг удирдлага зохион байгуулалтаар хангах, хяналт тавих үүргийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс хариуцна.

8.2. Аймгийн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар, Ахмадын байгууллагууд, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Боловсрол, соёл урлагийн газар, Эрүүл мэндийн газар, Насан туршийн боловсролын алба, сумдын Засаг даргын Тамгын газар, сумдын Нийгмийн түншлэлийн багууд, хөтөлбөр, төслийн газруудын оролцоотойгоор хамтран хэрэгжүүлнэ.

Ес. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилт

9.1. Хөтөлбөрийн санхүүжилт дараах эх үүсвэрээс бүрдэнэ.

9.1.1. Улсын төсөв

9.1.2. Орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө

9.1.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

9.1.4. Орон нутгийн хөгжлийг дэмжих сан

9.1.5. Аймгийн Засаг даргын нөөц

9.1.6. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын хуралдаанаас “Ахмадаа ачилъя” аймгийн дэд хөтөлбөрт хуваарилсан санхүүжилт

9.1.7. Нийгмийн халамжийн сан

9.1.8. Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангийн хүрээнд хуваарилсан хөрөнгө

9.1.9. Дотоод, гадаадын хандивлагч байгууллагуудын зээл тусламж, төсөл

9.1.10. Аж ахуй нэгж байгууллага, иргэдийн хандив, зээл тусламж

Арав. Хяналт, үнэлгээ, тайлагналт

10.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдалд хяналт, үнэлгээ хийх ажлыг аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг эрхлэн гүйцэтгэнэ. Хөтөлбөрийн хяналт, үнэлгээ хийх ажлын хэсэгт аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хэлтэс, аймгийн Ахмадын хороо, иргэд, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байна.

10.2. Хөтөлбөрийн хяналт, үнэлгээний ажлын зорилго нь хөтөлбөрт дэвшүүлсэн үр дүн, шалгуур үзүүлэлт, зорилтыг хангахад чиглэсэн үйл ажиллагааны хэрэгжилт, удирдлага, зохион байгуулалт, туршлага, сургамжийг нэгтгэн дүгнэх, хөтөлбөрийг санхүүжүүлэхэд зарцуулсан хөрөнгө хүндээ хэрхэн хүрч зохих дэмжлэг болж чадсаныг судалгаа, шинжилгээ, олон нийтийн оролцооны аргаар тогтоох, цаг үеийн байдалтай холбогдуулан хөтөлбөрийг шинэчлэн сайжруулах, зөвлөмж, санал дүгнэлт гаргана.

10.3. Орон нутагт хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавих ажлыг сумдын Засаг даргаар удирдуулсан Нийгмийн түншлэлийн баг, мэргэжлийн байгууллагатай хамтран гүйцэтгэнэ.

10.4. Орон нутгийн түвшинд зохион байгуулсан ажлын явц, үр дүнг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэст жил бүрийн 06 дугаар сарын 25, 12 дугаар сарын 15-ны дотор жилд 2 удаа тайлагнана.

10.5. Аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс нь хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн Засаг даргын зөвлөл, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн хуралд жил бүр тайлагнана.